



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/660

Булган сум

Булган аймгийн Шүүхийн Тамгын газарт сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 67.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIV/08 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Шүүхийн Тамгын газраас зохион байгуулж буй “Шүүхийн иргэдийн төлөөлөгч тэдгээрийн оролцоо, эрх үүрэг” сэдэвт сургалтад 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Сургалтад шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэгийг “Бүх нийтийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3.Сургалтад хяналт тавьж, тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Одхүү)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

